

БАТЛАВ:

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ”  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.УДААНЖАРГАЛ

БАТЛАВ:

“УРБАН ДЕВЕЛОПМЕНТ  
КОНСАЛТИНГ ГРУПП” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Д.ЭНХМАНЛАЙ

**БОГДХАН ТӨМӨР ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2022 оны 04 сарын 25-ны өдөр

№ АГГ-01/28/16

Улаанбаатар хот

Энэхүү Богдхан төмөр замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил гүйцэтгэх гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г

Нэг талаас “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК  
цаашид “Захиалагч” гэх/

Нэгөө талаас “ УРБАН ДЕВЕЛОПМЕНТ КОНСАЛТИНГ ГРУПП /цаашид “Гүйцэтгэгч” гэх/

нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ гэрээ байгуулах үндэслэл болсон нөхцөл байдлыг бүрэн судлан үзсэний үндсэн дээр талуудын харилцан тохиролцоо, үүрэг, амлалтыг үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь “БОГДХАН ТӨМӨР ЗАМ”-ын нарийвчилсан зураг төсөл боловсруулах Ажлын даалгаварт тусгагдсаны дагуу захиалагчтай зөвшилцсэний үндсэн дээр /цаашид “Зураг төсөл” гэх/ мэргэжлийн өндөр түвшинд зохиох, боловсруулах, зураг төслийг эрх бүхий байгууллагаар батлуулах ажлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх, Захиалагч нь Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлыг чанарын хяналт тавин хүлээн авч, гэрээгээр тохирсон төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээний 1.1-д дурдсан “БОГДХАН ТӨМӨР ЗАМ”-ын нарийвчилсан зураг төсөл боловсруулна. Үүнд:

- 1.2.1. Геологийн судалгаа
- 1.2.2. Ус зүйн судалгаа
- 1.2.3. Нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулах
- 1.2.4. Гүүр хоолойн ажлын зураг
- 1.2.5. Бусад

1.3. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлын мөн чанар, цар хүрээ, мөн ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж болох хүчин зүйл зэрэгтэй танилцаж ойлгосон болно. Үүнд: байгаль, цаг уур, газрын хөрс, тогтоц, дэд бүтэц, ажлын даалгавар, хууль тогтоомж, дүрэм журам зэрэг хамаарна. Эдгээр нөхцөл байдал, хүчин зүйлтэй танилцаагүй гэх шалтгаан нь Гүйцэтгэгчийг гэрээний үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

1.4. Энэхүү гэрээний бүх хавсралт гэрээний салшгүй хэсэг байна.

Хуудсыг баталгаажуулсан:



1.5. Дор дурдсан баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дараах дарааллын дагуу хүчин чадалтайд тооцно:

- 1.5.1. Гэрээ;
- 1.5.2. Богдхан төмөр замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар;
- 1.5.3. Гэрээний тусгай нөхцөл /ГТН/;
- 1.5.4. Гэрээний ерөнхий нөхцөл /ГЕН/;
- 1.5.5. Бусад хавсралт

1.6. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх эрхтэй болохоо 20/A97/17 дугаартай тусгай зөвшөөрөл, улсын бүртгэлийн гэрчилгээгээр нотлох бөгөөд эдгээд баримт бичгийг гэрээнд хавсаргана. Гүйцэтгэгч гэрээний энэ хэсэгт заасан баримт бичгийн үнэн зөвийг хариуцна.


1.7. Гүйцэтгэгч гэрээнд заасан төлбөрийн хэмжээ, нөхцөлийг хүлээн зөвшөөрч ажлыг бүрэн гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх ба талууд гэрээний төлбөрийн хэмжээ, нөхцөлийг гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх бүх хугацаанд өөрчлөхгүй байхаар тохиролцлов.

1.8. Захиалагч Гэрээний дүнг хүлээн зөвшөөрч, гэрээнд заасан төлбөрийн нөхцөлийг баримтлан Гүйцэтгэгчид төлбөрийг төлнө.

1.9. Энэхүү гэрээний дүн 13 617 034 829 (Арван гурван тэрбум зургаан зуун арван долоон сая гучин дөрвөн мянга найман зуун хорин ес) төгрөг байна.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### ЗАХИАЛАГЧ:

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ийг  
төлөөлж,  
  
Э.ЭРДЭНЭБАТ  
ТӨСӨЛ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

##### ГҮЙЦЭТГЭГЧ:

“УРБАН ДЕВЕЛОПМЕНТ КОНСАЛТИНГ  
ГРУПП” ХХК-ийг төлөөлж,  
  
Ц.БАЯРХҮҮ  
ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮ  
ХАРИУЦСАН ДЭЛ ЗАХИРАЛ

Хуудсыг баталгаажуулсан:



# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ /ГЕН/

## НЭГ. НЭР ТОМЬЁО

- 1.1. Гэрээнд заасан нэр томъёог тухайн зүйл хэсэгт өөрөөр тайлбарлаагүй бол дараах утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.1.1. "Эрх бүхий албан тушаалтан" гэж гэрээ, хэлцэл байгуулахад шууд болон шууд бусаар оролцож буй гэрээ батлах болон гэрээ байгуулахаар гарын үсэг зурах эрх хууль, итгэмжлэлээр олгогдсон этгээдийг хэлнэ.
  - 1.1.2 "Нарийвчилсан зураг төслийн баримт бичигт экспертиз хийх этгээд" гэдэгт Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн зураг төсөлд экспертиз хийх, дүгнэлт гаргах эрхтэй этгээд хамаарна.
  - 1.1.3 "Зургийн даалгавар" гэж энэ гэрээний ерөнхий зүйлийн 1.5.2-т заасан баримт бичгийг хэлнэ.

**ХОЁР. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

### **2.1. Хугацаа:**

- 2.1.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан ажил эхлэх өдөр ажлыг эхлүүлж, ажил дуусах өдөр ажлын үр дүнг Захиалагчид актаар хүлээлгэн өгнө.
- 2.1.2. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулан хүчин төгөлдөр болсон өдрийг гэрээт ажил эхэлсэн өдөрт тооцно.
- 2.1.3. Гүйцэтгэгчийн анх ирүүлсэн зураг төсөлд захиалагчийн эсхүл хөндлөнгийн эрх бүхий байгууллагын үндэслэл бүхий саналаар дахин ажиллаж өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгасан зураг төсөл эрх бүхий байгууллагаас батлагдсан хугацааг зураг төслийн ажлын үр дүнг хүлээн авсанд тооцно.

### **2.2. Ажил хүлээлцэх:**

- 2.2.1. Ажлын гүйцэтгэл, Гүйцэтгэгчийн ирүүлсэн баримт бичгийг үндэслэн талууд ажил хүлээлцэх тухай акт үйлдэнэ. ГЕН-ийн 1.1.2 дахь хэсэгт зааснаар эрх бүхий байгууллагаас гэрээнд заасан зураг төслийг баталснаар ажлын эцсийн үр дүнг хүлээн авсанд тооцно.

### **2.3. Чанар:**


- 2.3.1. Гүйцэтгэгч нь Гэрээт ажлыг Захиалагчийн зургийн даалгавар болон дотоодын хууль тогтоомж, барилгын норм, дүрэмд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

**ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

### **3.1. Хугацаа:**

- 3.1.1. ГТН-д заасан гэрээний нийт үнийн дунд татвар /НӨАТ болон бусад/, хураамж, ажиллах хүчний зардал зэрэг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бүх зардлууд багтсан эцсийн үнэ бөгөөд цаашид өөрчлөгдөхгүй байхаар, Гүйцэтгэгч нь Захиалагчаас энэхүү үнийн дүнгээс илүү төлбөр шаардахгүй байхаар талууд тохиролцов.
- 3.1.2. Нарийвчилсан зураг төсөлд их хэмжээний өөрчлөлт (20-иос доошгүй хувь) оруулах үндэслэл, шаардлага үүсвэл Захиалагч болон Гүйцэтгэгч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гүйцэтгэнэ.
- 3.1.3. Гүйцэтгэгчийн өөрийн гаргасан алдаа, эсхүл Гүйцэтгэгч шаардлага хангаагүй доголдолтой ажил гүйцэтгэсэн, Гүйцэтгэгч ажлын даалгаврыг зөрчсөн, биелүүлээгүйгээс үүдэн зураг төсөлд өөрчлөлт орсон тохиолдолд Захиалагч нэмэлт төлбөр төлөхгүй.
- 3.1.4. Зураг төслийг эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэх, батлуулах, дүгнэлт гаргуулах, шалгуулах бүхий л зардал нь энэхүү гэрээний үнийн дунд багтсан бөгөөд уг хугацаанд дээрх байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас аливаа өөрчлөлт

Хуудсыг баталгаажуулсан:



оруулсан тохиолдолд уг ажлын үнэ мөн энэ гэрээний 1.9-д заасан дунд багтсан болно.

### **3.2. Төлбөрийн нөхцөл:**

- 3.2.1. Гэрээний үнийг ГТН-д заасан хуваарийн дагуу талуудын хүлээн зөвшөөрсөн ажлын гүйцэтгэлийн акт, төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн, ГТН-д өөрөөр заагаагүй бол ажлын гурван (3) өдөрт багтаан олгоно.
- 3.2.2. Гэрээний төлбөрийг Гүйцэтгэгч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тохиолдолд олгоно.
- 3.2.3. Гүйцэтгэгчийн ажил Хавсралтад заагдсан гүйцэтгэвэл зохих хувьд хүрээгүй бол тухайн хувьд хүрэх хүртэл ажлын хөлс олгогдохгүй.

## **ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **4.1. Захиалагч нь дараах эрхтэй:**

- 4.1.1. Ажлыг холбогдох хууль тогтоомж болон барилгын норм ба дүрэм, стандарт шаардлага, орчин үеийн дэвшилтэй чиг хандлага, төслийн ашигтай байх зарчмыг баримтлан гэрээнд заасан хугацаанд нь гүйцэтгэхийг шаардах;
- 4.1.2. Ажлыг хүлээн авах үед эсвэл Экспертизээр батлуулах үед зураг төсөл нь дутагдалтай, холбогдох чанарын шаардлагыг хангахгүй байгаа нь хөндлөнгийн мэргэжлийн эрх бүхий байгууллагаар тогтоогдсон тохиолдолд нэмэлт хугацаа тогтоон өгч, тус хугацаанд Гүйцэтгэгчийг өөрийн зардлаар засах буюу шинээр гүйцэтгэхийг шаардах;
- 4.1.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;
- 4.1.4. Захиалагч нь зураг төслийг хүлээн авсанаар түүний зохиогчийн эрхтэй холбоотой аливаа эрхийг дангаар эдлэх буюу гэрээний үр дүнг өмчлөх эрхтэй байна.

### **4.2. Захиалагч нь дараах үүрэгтэй:**

- 4.2.1. Гүйцэтгэгчтэй хамтран хийсэн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах;
- 4.2.2. Гэрээнд заасны дагуу төлбөрийг төлөх;
- 4.2.3. Ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох тухай албан ёсоор мэдэгдэх буюу мэдэгдэл өгсөн бол мэдэгдэл өгөх хүртэл хугацаанд хийгдсэн ажлын талаар харилцан акт үйлдэж, гүйцэтгэсэн ажлын төлбөрийг харилцан тохиролцож барагдуулах;
- 4.2.4. Захиалагчаас хамааралтай өгөгдөл, технологийн даалгавар, мэдээллийг Гүйцэтгэгчийн зургийн инженерийн шаардсанаар ажлын гурван (3) өдөрт дотор гаргаж өгнө. Зураг төсөл зохиоход шаардлагатай тулгуур баримт бичиг, мэдээллийг гэрээ байгуулагдсанаас хойш ажлын таван (5) өдрийн дотор гаргаж өгнө. Үүнд:
  - 4.2.4.1. Зургийн даалгавар;
- 4.2.5. Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан олж авсан, мэдсэн Гүйцэтгэгчтэй холбогдолтой аливаа мэдээлэл, баримт материал, зураглал, тооцооллын нууцлалыг чанд хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглуулахгүй, задруулахгүй, нийтэд ил болгохгүй байх үүрэгтэй.

## **ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **5.1. Гүйцэтгэгч нь дараах эрхтэй:**

- 5.1.1. Гэрээнд заасан журмаар Захиалагчаас төлбөрөө шаардах, авах;
  - 5.1.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах.
- 5.2 Гэрээний хавсралт 1-т заасан ажлын даалгаврын дагуу захиалагчийн шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. Монгол улсын хэмжээнд олон улсад мөрдөгдөж буй стандарт, орчин үеийн шаардлагад нийцсэн технологиор, чанарын өндөр төвшинд, гэрээнд заасан хугацаанд хийж, гүйцэтгэнэ. Ажлыг гүйцэтгэхдээ дараах хавсралтад заасныг баримтална.

- 5.2.1. Хавсралт 1 – Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар нь гэрээний салшгүй нэг хэсэг мөн.

### **5.3. Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй:**

- 5.3.1. Ажлыг Гэрээнд заасан хугацаа, нөхцөлөөр, өөрийн материал, багаж, техник хэрэгсэл, программ хангамж, ажиллах хүчийг ашиглан доголдолгүй, зургийн даалгавар, энэхүү

Хуудсыг баталгаажуулсан:



гэрээний Хавсралт №1-т заасан болон доорх шаардлагуудад нийцүүлэн хийж гүйцэтгэн захиалагчид ажлын үр дүнг хүлээлгэн өгнө. Үүнд:

- Нарийвчилсан зураг төслийн баримт бичгийг Зургийн даалгаврын дагуу Захиалагчтай харилцан зөвшилцэж хийх;
  - Нарийвчилсан зураг төслийн баримт бичгийг холбогдох норм дүрэм стандартын дагуу гүйцэтгэх;
  - Зураг төслийг өөрийн байгууллагын зүгээс баталгаажуулах;
  - Захиалагчид батлагдсан зураг төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр бэлтгэж хүлээлгэн өгөх;
- 5.3.2. Гэрээнд заасан ажил нь дутагдалтай, холбогдох хууль тогтоомж, барилгын норм, дүрэм журам болон гэрээнд заасан шаардлагад нийцэхгүй байгаа нь хөндлөнгийн эрх бүхий/мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон тохиолдолд Гүйцэтгэгч тогтоосон хугацаанд өөрийн зардлаар шуурхай засах эсхүл шинээр хийж гүйцэтгэх;
- 5.3.3. Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан олж авсан, мэдсэн Захиалагчид холбогдолтой аливаа мэдээлэл, баримт материал, зураглал, тооцооллын нууцлалыг чанд хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглуулахгүй, задруулахгүй, нийтэд ил болгохгүй байх;
- 5.3.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ Захиалагчид мэдэгдэж бичгээр зөвшөөрөл авалгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээ байгуулахгүй байх;
- 5.3.5. Захиалагчаас гаргаж өгсөн баримт материал нь буруу, алдаатай байснаас үүссэн ажлын дутагдал доголдолд хариуцлага хүлээхгүй;
- 5.3.6. Зураг төслийг Захиалагчийн гаргасан зургийн даалгаврын дагуу холбогдох хууль тогтоомж, барилгын норм, дүрэмд заасны дагуу хийж гүйцэтгэх бөгөөд экспертиз, баталгаажилт хийгдэх үеийн хөндлөнгийн эрх бүхий байгууллага/албан тушаалтны үндэслэл бүхий шаардлагад заасны дагуу зураг төслийг Гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлах, эсхүл шинээр хийж гүйцэтгэнэ.
- 5.3.7. Гүйцэтгэх ажилд Захиалагчаас шаардлагатай зүйл бий бол нэн даруй энэ талаар Захиалагчид имэйлээр, эсхүл албан бичгээр мэдэгдэж, шаардлагатай мэдээлэл, баримтыг Захиалагчаас гаргуулан авах үүрэгтэй.
- 5.3.8. Гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх.
- 5.4. Зураг төсөл зохиогч өөрийн нарийвчилсан зураг төслийн дагуу барилга угсралтын ажил хийгдэж байгаа эсэхэд зураг төсөл, зохиогчийн хяналтыг сард нэгээс доoshгүй удаа хийх, шаардлагатай тохиолдолд /захиалагчийн шаардлагын дагуу/ хувираас гадна төслийн талбай дээр ирж заавар, зөвлөгөөг тухай бүрт өгч ажиллах.
- 5.5. Монгол улсын авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч хариуцаж, гарсан хохирлыг барагдуулна.
- 5.6. Энэхүү гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол илэрвэл Гүйцэтгэгч доголдлыг өөрийн зардлаар арилгах үүрэг хүлээнэ. Доголдол гэдэгт Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан стандарт журмыг баримтлаагүй эсвэл тоо хэмжээ, зургийн тооцоолол болон хөрөнгө оруулалтын дүн зэрэг алдаатай, шаардлагад нийцээгүй, дутуу гүйцэтгэх зэргийг хамааруулан ойлгоно.

## ЗУРГАА. ХАРИУЦЛАГА


### 6.1. Алданги:

- 6.1.1. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд гүйцэтгэж чадаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх хэмжээний алдангийг Захиалагчид төлнө. Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнг тодорхойлох боломжгүй бол Гэрээний нийт үнийн дүнгээс тооцно.

### 6.2. Бусад хариуцлага:

- 6.2.1. Энэхүү гэрээний бусад нөхцөлд өөрөөр заагаагүй бол талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан бодит хохирол/алданги, торгуулиас үл хамааран/-ыг хариуцна.

Хуудсыг баталгаажуулсан:



- 6.2.2. Талуудын хэн аль нь гэрээгээр хүлээсэн, энэ гэрээнд заасан хугацаагаар үл хязгаарлагдах үүргээ зөрчсөн, эсхүл гүйцэтгээгүй бол гэрээний үнийн дүнгийн арван (10) хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг буруугүй талдаа төлнө.

## ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

### 7.1. Нууцлал:

- 7.1.1. Гэрээний дагуу гүйцэтгэсэн зураг төсөл, гэрээгээр хэрэгжих төсөл, гэрээ, түүний хавсралтууд, талуудын хооронд шилжүүлсэн бичиг баримт, тооцоо, санал зөвлөмж нь санхүү, аж ахуйн үйл ажиллагааны нууцад хамаарах бөгөөд нууцлалыг Гэрээ байгуулагдсанаас хойш хугацаагүйгээр чанд хадгалах ба нөгөө Тал зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, Гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байхаар тохиролцов.
- 7.2.2. Талууд зөвхөн шаардлагатай мэдээллийг тухайн ажлыг гүйцэтгэх ажилтанд өгнө. Талууд санхүү, аж ахуйн үйл ажиллагааны нууцыг задруулахгүй байх, ашиг орлого олох зорилгоор ашиглахгүй байх, тийм нөхцөл бүрдүүлэхгүй байх үүрэгтэй. Гүйцэтгэгч нь гэрээ хэрэгжиж дууссаны дараа цахим болон цаасан хэлбэрээр өөрт байгаа бүх бичиг баримтыг Захиалагчид шилжүүлэн өгөх, илүү хувийг устгах үүрэг хүлээнэ.

## НАЙМ. ТАЛУУД ХАРИЛЦАХ

- 8.1. Гэрээтэй холбоотойгоор Талууд хоорондоо харилцахдаа ГТН-д заасан мэдээллийг үндэслэнэ.
- 8.2. Хэрэв Талуудын аль нэг нь ГТН-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын таван (5) өдрийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүйгээс үүссэн аливаа хохирол, зардлыг мэдэгдээгүй тал нь бүрэн хариуцна.


## ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1. **Зөвшилцөх:** Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
- 9.2. **Шүүх:** Хэрэв Гэрээний 9.1 дэх хэсэгт заасан аргаар маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## АРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 10.1. Гэнэтийн ба Давагдашгүй хүчин зүйл гэж нэрвэгдэгч талын санаатай, хайхрамжгүй, эсхүл буруутай үйлдэл, эс үйлдлээс болоогүй, түүнийг урьдчилан мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан ба өөрийн бүх боломжоор түүнийг даван туулах, эсхүл зайлзуулах буюу үр дагаврыг нь бууруулах арга хэмжээ авсан, гэрээний үүргээ гүйцэтгэх боломжгүйд шууд хүргэсэн нөхцөл байдлыг хэлнэ. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлд дараах нөхцөл байдал хамаарна:
- 10.1.1. Дайн, зэвсэглэсэн бослого, бослого, гадны түрэмгийлэл, дайралт, хувьсгал, нийтээрээ хориглох, оршин суугчдын эсэргүүцэл, иргэний болон төрийн бус байгууллагын эсэргүүцэл;
- 10.1.2. Байгалийн гамшиг тухайлбал, ноцтой нөлөөлөх шуурга, хар салхи, ноцтой нөлөөлөх газар хөдлөлт, үер, аюултай хэмжээтэй цас, гал эсхүл аянганаас үүдсэн сүйрэл;
- 10.1.3. Нийтийг хамарсан тахал, өвчинөөс шалтгаалж хорио цээрийн дэглэм албан ёсоор тогтоох;
- 10.1.4. Захиргааны хууль ёсны болон хууль бус хориглосон шийдвэр, эд хөрөнгө хураах, албадан авах, бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нийгэмлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулсан нь үүргийн гүйцэтгэлд ноцтой нөлөөлсөн, тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрлийг хууль бусаар цуцалсан, тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрөл сунгахаас хууль бусаар татгалзсан, эсхүл олгохоос татгалзсан.

Хуудсыг баталгаажуулсан:



- 10.2. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал ("нэрвэгдсэн тал") нь энэ тухайгаа долоо (7) хоногийн дотор нөгөө талдаа дараах мэдээллийн хамт мэдэгдэнэ:
- 10.2.1. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн талаар нотлох баримт бүхий тодорхой мэдээлэл;
  - 10.2.2. Үүргийн гүйцэтгэлд гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөх хүрээ, цаашдын таамаг;
  - 10.2.3. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаа эсхүл энэ талаархи таамаг;
  - 10.2.4. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн үр дагаврыг бууруулах зорилгоор авсан эсхүл авахаар төлөвлөсөн арга арга хэмжээ.
- 10.3. Нэрвэгдсэн тал нь гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын талаар хоног тутам нөгөө талдаа мэдэгдэнэ.
- 10.4. Хэрэв нөгөө тал нь гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн талаарх мэдэгдлийг хүлээн зөвшөөрсөн бол нэрвэгдсэн тал нь давагдашгүй хүчин зүйлээс үүдэн үүргээ гүйцэтгээгүйн хариуцлагаас чөлөөлөгджэй, тухайн үүргийн гүйцэтгэл нь гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл арилтал эсхүл цуцлагдах хүртэл хойшлогдоно.
- 10.5. Нэрвэгдсэн талын хүсэлтээр, нөгөө тал нь хүлээн зөвшөөрсөн гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан зардлыг талууд тус бүр өөрсдөө хариуцаж төлнө.
- 10.6. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл хуанлийн арван тав (15) хоногоос илүү хугацаагаар үргэлжилсэн эсвэл ийнхүү үргэлжлэх нь гарцаагүй гэж Талууд үзсэн нөхцөлд Талууд харилцан тохиролцож гэрээний нөхцлийг өөрчлөх эсвэл гэрээг цуцалж болно. Хэрэв гэрээ цуцлагдсан бол аль ч тал цуцалснаас үүдэх хохирлыг нэхэмжлэхгүй ба Захиалагч зөвхөн тухайн гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл эхэлсэн өдөр хүртэлх зохих ёсоор хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөх бөгөөд гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авна.
- 10.7. Хэрэв тухайн тохиолдол гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлд хамаарах эсэх талаар талууд зөрөлдвөл талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр зөрөлдөөнийг Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимиын холбогдох хэлтсээр шийдвэрлүүлж болно.

## АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1. Гэрээ хүчин төгөлдөр болох: Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. Талууд Гэрээ дуусгавар болгохтой холбоотойгоор Гэрээг дүгнэсэн акт үйлдэж болно.
- 11.2. Нэмэлт, өөрчлөлт: Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 11.3. Гэрээг цуцлах: Гэрээний аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй ноцтой зөрчил гаргасан бол гэрээний аль нэг тал өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй бөгөөд тийнхүү цуцалснаас нөгөө талд учирсан бодит хохирлыг 6.2.1 дэх хэсэгт заасны дагуу гэм буруутай тал хариуцна.
- 11.4. Хэрэглэгдэх хууль: Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 11.5. Санал, хүсэлт: Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, Гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл болон Гэрээтэй холбогдон нэг талаас нөгөө талдаа гаргаж буй аливаа санал, мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэж гурав (3)-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа Гэрээнд заасан хаягаар эсвэл биечлэн хүргүүлснийг хүчинтэйд тооцно.
- 11.6. Гэрээний эх хувь: Гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

--000--

Хуудсыг баталгаажуулсан:



**БОГДХАН ТӨМӨР ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Гэрээний № АГГ-61/28/16

ЗАХИАЛАГЧ:  
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК

ГҮЙЦЭТГЭГЧ:  
“УРБАН ДЕВЕЛОПМЕНТ КОНСАЛТИНГ  
ГРУПП” ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14230/, Нарны зам-62 Юнион Бюлдинг, Б блок, 11 давхар

Утас: 7777-7727

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-17, Блю Скай Тауэр 408 тоот

Утас: 99105943, 70100123

2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Хуудсыг баталгаажуулсан:



## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ /ГТН/

1	<b>Зураг төслийн бүрдэл</b>  <b>Үе шат</b> <ul style="list-style-type: none"> <li>▪ Чигийн дагуу инженер геологийн судалгаа;</li> <li>▪ Нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулах;</li> <li>▪ Гүүр, хоолойн ажлын зураг;</li> <li>▪ Мал, амьтны нүхэн гарцын ажлын зураг;</li> <li>▪ Төмөр замын зурvas газрын зураг боловсруулах;</li> </ul> <b>Зураг төслийн иж бүрдэл</b> <ul style="list-style-type: none"> <li>• Инженер, геологийн судалгааны ажлын тайлан;</li> <li>• Зургийн тайлбар бичгийн иж бүрдэл;</li> <li>• Инженерийн нарийвчилсан зураг, ус зайлцуулах байгууламжийн тооцоо;</li> </ul>	Зураг төслийн иж бүрдэлийг дараах байдлаар гүйцэтгэнэ.
2	<b>Ажилд тавигдах бусад шаардлага</b>	Захиалагч холбогдох хууль тогтоомжийн зохицуулалт, норм, дүрэм журамд заасны дагуу жишиг зургийн даалгаврыг бэлтгэж, Гүйцэтгэгчид гаргаж өгөх ба Гүйцэтгэгч нь зургийн даалгаврын ("Зургийн даалгавар") дагуу Нарийвчилсан зураг төслийн ажлыг энэхүү гэрээнд заасны дагуу хийж гүйцэтгэн, эрх бүхий байгууллагаар батлуулан Захиалагчид хүлээлгэн өгнө.
3	<b>Зураг төсөл боловсруулах үе шат, ажил гүйцэтгэх хугацаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Чигийн дагуу инженер геологийн судалгаа: 2022.06.01- 2022. 07.01</li> <li>▪ Нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулах; А. Доод бүтэц: 2022.06.01- 2022. 07.01 Б. Дээд бүтэц: 2022.06.01- 2022. 08.01</li> <li>▪ Гүүр, хоолойн ажлын зураг: 2022.06.01- 2022. 08.01</li> <li>▪ Мал, амьтны нүхэн гарцын ажлын зураг 2022.06.01- 2022.08.01</li> <li>▪ Төмөр замын зурvas газрын зураг боловсруулах 2022.06.01- 2022.07.10</li> </ul>
4	<b>Захиалагчийн гаргаж өгөх мэдээ, материал</b>	1. Ажлын даалгавар 1а. Инженерийн нарийвчилсан зураг төсөл 1б. Гүүр, хоолойн нарийвчилсан зураг төсөл 1в. Төмөр замын зурvas газрын ажлын зураг 1г. Инженер геологи
5	<b>Ажил эхлэх огноо</b>	Талууд гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг дарж хүчин төгөлдөр болсон өдрийг гэрээт ажлыг эхлүүлэх хугацаанд тооцно.
6	<b>Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн нэр, албан тушаал</b>	"Урбан девелопмент консалтинг групп" ХХК-ийг төлөөлж Захирал Д.Энхманлай
	<b>Утас, цахим шуудан</b>	Утас: 99105943 enkhmanlai@udcgroup.mn
7	<b>Нийт үнэ /НӨАТ багтсан дүн/</b>	Чигийн дагуу инженер геологийн судалгаа – 1 393 190 251 Нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулах – 5 390 400 000 Гүүр, хоолойн ажлын зураг – 4 376 844 211 Мал, амьтны нүхэн гарцын ажлын зураг – 1 313 053 151 Төмөр замын зурvas газрын зураг боловсруулах – 290 062 500 Магадлал хийлгэх /Хэсэгчлэх/ - 853 484 716 <i>/Нийт - 13 617 034 829 (Арван гурван тэрбум зургаан зуун арван долоон сая гучин дөрвөн мянга найман зуун хорин ес) төгрөг</i>

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАИХАА

**ХЯНАГДАВ**


Ажилтнуу  
2022 он. 11 сар 27-дөрөө

Хуудсыг баталгаажуулсан:

8	<b>Төлбөр тооцоогүйцэтгэх:</b>	Энэхүү гэрээнд заасан дансанд бэлэн бусаар, дараах төлбөрт нөхцөлөөр төгрөгөөр төлнэ.
8.1	<b>Төлбөр төлөх хугацаа</b>	Гэрээний тусгай нөхцөлийн 3-т заасны дагуу зураг төсөл боловсруулах ўе шат, ажил гүйцэтгэх хугацаа бүрэн дуусч, магадлагдан, хоёр тал нарийвчилсан ажлын зургийг актаар хүлээлцсэний үндсэн дээр гэрээний төлбөрийг 100% шилжүүлнэ.
8.2	<b>Гүйцэтгэгчийн дансны мэдээлэл</b>	Банк: Худалдаа хөгжлийн банк Данс: 800008641 Худалдаа хөгжлийн банк Эзэмшигч: Урбан девелопмент консалтинг групп
9	<b>Тайлан гаргах хуваарь:</b>	Нийт 3 удаа тайлан гаргаж Захиалагчид хүргүүлнэ.
9.1	<b>Эхлэлийн тайлан</b>	Гэрээ байгуулагдаж, Зураг төсөл боловсруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулсанаар
9.2	<b>Дунд шатны тайлан</b>	Ажлын зургийг бүрэн дуусгаж /Магадлалд орохын өмнөхөөр /
9.3	<b>Эцсийн тайлан</b>	Иж бүрэн зураг төслийг Захиалагчид хүлээлгэж өгсөнөөр

### Хуудсыг баталгаажуулсан:





**БОГДХАН ТӨМӨР ЗАМЫН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГАА, ИНЖЕНЕРИЙН  
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

1.	Төслийн товч танилцуулга	<p>Энэхүү төсөл нь Монгол Улсын төмөр замын өнөөгийн сүлжээг сайжруулах бодлогын хүрээнд Улаанбаатар хотын дундуур дайран өнгөрч буй төмөр замын зорчигч болон ачаа тээврийн хөдөлгөөний эрчимжилтийг бууруулах, дотоодын болон олон улсын ачаа тээврийг нийслэл хотыг тойруулан явуулах боломжийг хангах, улмаар хотын тээврийн сүлжээг сайжруулан, түгжрэлийг бууруулахад бодит хувь нэмэр оруулах төмөр замын шинэ шугамыг барих төсөл юм.</p> <p>Богдан төмөр замын шугам нь "УБТЗ" ХНН-ийн Рашаант өртөөнөөс эхэлж, Богдан уулын урдуур тойрон, Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал, ачаа тээврийн цогцолбор терминалын хажуугаар өнгөрч, Мааньт өртөөний замтай холбогдох төмөр замын дээд, доод бүтэц, эстакад, туннел, гүүр, хоолой, хориг хашаа зэрэг инженерийн байгууламж, өртөө, зөрлөгийн барилга байгууламж, галт тэрэгний хэвийн үйл ажиллагааг хангах дохиолол, холбооны систем, эрчим хүч, барилга байгууламж, зам засварын төв, ажиллагсдын орон сууц зэрэг технологийн иж бүрдлийг барьж байгуулах томоохон бүтээн байгуулалтын ажил юм.</p> <p>Богдан төмөр замын суурь бүтэц нь жилд 30 сая тонн ба түүнээс дээш ачаа тээж нэвтрүүлэх хүчин чадалтай, MNS 6229:2021 стандартын ангиллын дагуу Гуравдугаар зэрэглэлийн төмөр зам юм.</p>
2.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн мн 206 дугаар тогтоол;</li><li>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 230 дугаар тогтоол;</li><li>Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлт;</li></ul>
3.	Захиалагч байгууллага	<ul style="list-style-type: none"><li>"Тавантолгой төмөр зам" ХХК</li></ul>
4.	Гүйцэтгэгч байгууллага	<ul style="list-style-type: none"><li>Төмөр замын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллага байна.</li></ul>
5.	Байршил	<ul style="list-style-type: none"><li>Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн Баян, Сэргэлэн, Алтанбулаг, Аргалант сумын нутаг дэвсгэр.</li></ul>
6.	Байгууламжийн газрын хэмжээ	<ul style="list-style-type: none"><li>Гол замын урт 144.9 км /Монгол улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 51 дугаар "Төмөр замын шугамын чиг тогтоох тухай" тогтоол/</li></ul>
7.	Төлөвлөлтийн бичиг баримт	<ul style="list-style-type: none"><li>Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрэм, журмууд</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>“1520 мм царигтай төмөр зам. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6229:2021 стандарт;</li> <li>“1520 мм-ийн царигтай төмөр замд барилга байгууламжийн ойртох хязгаар болон хөдлөх бүрэлдэхүүний овор” MNS 5833:2014;</li> <li>“Төмөр замын зурvas газарт тавих ерөнхий шаардлага” MNS 6060 : 2010;</li> <li>Шилэн кабелын суурилуулалт MNS 5207:2011;</li> <li>Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03;</li> <li>Барилгын инженер- геологи, геотехникийн судалгааны ажил БНБД 11-03-21</li> <li>“1:500 1:1000 1:2000 1:5000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил” БД11-106-08</li> <li>Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл БНБД 11-07-19</li> <li>Богдхан төмөр зам төслийн техник, эдийн засгийн үндэслэл</li> <li>Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад стандарт, норм норматив;</li> </ul>
8.	Төмөр замын эхлэл, төгсгөл	<ul style="list-style-type: none"> <li>Богдхан төмөр замын эхлэл, төгсгөл нь “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн үндсэн /гол/ замын Рашиант, Мааньт өртөөдтэй холбогдохоор төслөх;</li> <li>Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 08/3610 албан тоот “Богдхан төмөр замын трассын эхлэл, төгсгөлийг тодорхойлох техникийн нөхцөлийн дүгнэлт”-ийг баримтлах;</li> </ul>
9.	Замын техникийн ангилал, замын зэрэглэл, хүчин чадал	<ul style="list-style-type: none"> <li>Ачаа ба зорчигч тээвэр, транзит тээвэр;</li> <li>Замын зэрэглэл III;</li> <li>Жилд тээвэрлэх ачааны хэмжээ 30 сая.тонн;</li> </ul>
10.	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	<ul style="list-style-type: none"> <li>Зураг төсөл гүйцэтгэгч нь зураг төсөл боловсруулах календарьчилсан график гаргаж, захиалагчаар батлуулна;</li> <li>Зураг төслийн 2-оос багагүй хувилбар гаргаж 2 долоо хоногийн дараа захиалагчид ирүүлж, захиалагчаар сонгуулж батлуулах;</li> <li>Геологийн судалгааны тайлан, ус зүйн судалгааны тайланг гэрээ зурагдсанаас хойш 5 долоо хоногийн дараа захиалагчид ирүүлэх;</li> <li>Ажлын зураг төслийг гэрээ зурагдсанаас хойш 8 долоо хоногийн дараа захиалагчид ирүүлэх;</li> <li>Гэрээнд заасан буюу 2 сарын хугацаанд гүйцэтгэж магадлуулсан байх;</li> </ul>
11.	Техникийн шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>Цариг 1520 мм;</li> <li>Гол замын тоо – Нэг замтай (харин хонгил, эстакад нь ирээдүйд чигийн дагуу хос замтай, цахилгаан зүтгүүр ашиглах) байхаар төслөх;</li> <li>Замын төрөл – 25 м урттай, уулзвартай үет зам төмөртэй байхаар;</li> <li>Зам төмөр – ОХУ-ын ГОСТ Р 51685 – 2013 стандартын дагуу үйлдвэрлэсэн зам төмрүүдээс MNS 6229:2021 стандартын шаардлагад нийцүүлэн сонголт хийх;</li> <li>Тахирын хамгийн бага радиус – 1200м;</li> <li>Далангийн өргөн 7.3м;</li> <li>Балластын зузаан – 0.35м;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Төмөр бетон дэрийн бэхэлгээ - /бэхэлгээ бүрт тохирсон төмөр бетон дэртэй байх/;</li> <li>Суман шилжүүлэг – Ердийн 1/11, 1/9 марктай, битүү огтлолцлын 2/11 марктай;</li> <li>Удирдах хэвгий – тэгш - 7.5%, сондгой - 9%;</li> <li>Галт тэрэгний хурд – ачаатай 90 км/ц, хоосон 90км/ц;</li> <li>Замын дээд бүтэц – MNS 6229:2021 стандартын шаардлагыг хангана (туннель, эстакад дотор замын дээд бүтэц нь балластгүй хийцтэй байх чиглэлийг баримтална);</li> <li>Рашаант, Мааньт өртөөний замын өргөсгөлт, 2 өртөө, 6 зөрлөгтэй байхаар төслөх;</li> <li>Хүлээн авах, явуулах замын ашигтай урт Өртөө – 1800 м Зөрлөг – 1500 м</li> <li>Өртөө, хэсэглэх газар, депо бусад байнгын төхөөрөмжийн байршил, дэвсгэр зураг, дагуу огтлолыг ирээдүйд цахилгаан зүтгүүр ашиглах шаардлагын дагуу стандарт хэмжээт баримтлан төсөллөх;</li> </ul>
12.	Зураг төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> <li>Инженер-геологи, геотехникийн судалгааны ажлын тайлан;</li> <li>Ус зүйн судалгааны ажлын тайлан;</li> <li>Карьерийн судалгаа /төмөр замын далан, замын балластын давхаргад ашиглах хатуулга бүхий буталмал чулуу, бетоны дүүргэлтийн материал болох дайрга гэх мэт материалуудын их үүсвэрийг тодорхойлох/;</li> <li>Замын барилга угсралтын ажлын зураг төсөл;</li> <li>Замын барилга угсралтын ажлын нийт төсөв;</li> <li>Ажлын нэр төрөл, тоо хэмжээ;</li> <li>Газар шорооны ажил, замын дээд бүтэц гүүр хоолой, мал амьтны гарцын ажлын зураг төсөл, төсөв;</li> <li>Гол зам ба өртөө, зөрлөгийн замын доод бүтэц (замын трасс, ул шорооны овоолго буюу далан, сэтэрхий буюу ухмал, гүүр, хоолой, суваг, шуудуу зэрэг ус зайлцуулах болон бусад зориулалтын төхөөрөмж, байгууламжууд);</li> <li>Замын дээд бүтэц (зам тавих зураг, суман шилжүүлэг, зам төмөр, бетон дэр, бэхэлгээ, буталмал чулуун чижжээс, замын тэмдэгт, замын материалын зураг);</li> <li>Туннель, эстакад доторх замын дээд бүтцийн ажлын зураг төсөл, төсөв</li> <li>Замын дэвсгэр зураг, дагуу ба хөндлөн огтлол (тэнхлэг, түвшин, тахирын гадна талын зам төмрийн өндөрлөлт) болон замын бүхий л байгууламжийг багтаасан үндсэн бүрэлдэхүүн хэсэг бүрийн урт хугацааны шалгалт, засвар үйлчилгээний ажлын бүрэн хэмжээтэй дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан байна;</li> <li>Төмөр замын трасс дагуух барилга байгууламж, айл өрх, хашаа, эрчим хүчний шугамын болон шилэн кабель зэргийн огтлолцож буй хэсгийн оврын зураг төсөл, судалгаа;</li> <li>Зэрлэг ан амьтан, малын гарцын нарийвчилсан зураг боловсруулах;</li> <li>Зурvas газрын зураг боловсруулах /MNS6060:2010/;</li> <li>Замын тэмдэг тэмдэглэгээний зураг төсөл;</li> <li>Технологийн замын зураг төсөл;</li> <li>Ашиглах тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл;</li> <li>Ажил гүйцэтгэх аргачлал;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Газар шорооны ажил, замын дээд бүтэц, гүүр хоолойн ажил, мал амьтны гарцын техникийн шаардлагууд боловсруулах;</li> <li>Зураг төсөл, төсвийн магадлалын өрөнхий дүгнэлт;</li> </ul>
13.	Онцгой нөхцөл	<p>"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн одоогийн замтай уялдуулах нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн төмөр зам түүнийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны төлөвлөгөөтэй уялдуулах;</li> <li>Бодхан төмөр замын трасс "УБТЗ" ХНН-ийн суурь бүтэцтэй зэрэгцэн явах хэсэгт замын доод бүтэц, далан, ухмал, гүүр, хоолой, суваг шуудууг харилцан уялдуулах, төмөр замын зурvas газар, аюултай бүсийн дэглэмийн нөхцөлийг хангах;</li> <li>УБТЗ-ын Багахангай өртөө болон Сонгины замтай ирээдүйд холбогдох боломжийг зураг төсөлд харгалзан үзэх;</li> <li>Замын тэмдэг тэмдэглэгээг төлавлөхдөө "УБТЗ" ХНН-ийн хэмжээнд мөрдөгддөг стандарт, дүрэм журмын шаардлагыг хангасан, аль болох ижил, төстэй байхаар сонгож төлөвлөх;</li> </ul> <p>Замын техникийн байдалд тавигдах нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>Ирээдүйд баригдах хос замын нөхцөл, шаардлагыг ханган төлөвлөх;</li> <li>Зорчигчийн галт тэрэг аялах үед зорчигчдын ая тухтай нөхцөл, аюулгүй байдлыг хангах зорилгоор замын тахир хэсгийн радиусыг аль болох ихэсгэх, уртыг багасгах зэргээр стандарт шаардлагад нийцүүлэн төслөх;</li> <li>Өртөө, зөрлөгийн замыг аль болох тэгш, шулуун хэсэгт байрлуулан төслөх, сэтэрхий дотор байрлуулахаас зайлсхийх;</li> <li>Гүүрийн хэсэг дэх төмөр замын чиг шугамыг шулуун байхаар төлөвлөх;</li> <li>Газар шорооны ажил, ухмал далангийн тоо хэмжээг харилцан ойролцоо буюу тэнцүү, хамгийн боломжит бага хэмжээнд байхаар төслөх;</li> <li>Хөдөлгөөний аюулгүй байдал хангах тэмдэг, тэмдэгжилтийг байрлуулах;</li> <li>Газар орны хүндрэлтэй нөхцөлд тохируулан технологийн замын байршилыг төлөвлөх;</li> <li>Технологийн замын тэнхлэг нь боломжтой нөхцөлд ухмал, далангийн хормойн ирмэгээс 55 м, замын өргөн нь 8 м, зузаан нь 250 мм-ээс тус тус багагүй байхаар төслөх;</li> <li>Төмөр замын трасс нь салхины зонхилох чигийн дагуу байрлаж буй тул цас, салхинаас хамгаалах, салхины хүчийг сааруулах зорилгоор ногоон байгууламж бүхий хамгаалалтын зурvasыг оновчтой төслөх;</li> </ul> <p>Авто зам, бусад инженерийн байгууламжуудтай огтлолцох нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын авто замын сүлжээ болон түүнийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны төлөвлөгөөтэй уялдуулах ажлыг захиалагч болон зураг төсөл зохиогч хамтран гүйцэтгэх;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>Улс хоорондын болон орон нутгийн сүлжээний авто замтай огтлолцох хэсгүүдийг стандарт, шаардлагын дагуу ижил бус төвшинд, аль болох эгц хөндлөн (перпендикулярь) огтлолцуулах, авто замын трассын хэсэгт огтлолцол өөрчлөгдөх бол өөрчлөлтийн иж бүрэн зураг төслийг боловсруулах;</li> <li>Төмөр замын чиг шугамын дагууд авто зам, цахилгаан дамжуулах шугам, шилэн кабель зэрэг инженерийн шугам сүлжээний болон бусад байгууламжуудтай огтлолцох хэсгийн байршилудыг тодорхойлж, нүүлгэн шилжүүлэх шаардлагатай нөхцөлийг тусгаж оврын судалгааг хийсэн байна;</li> <li>Дээрх нөхцөлд инженерийн шугам сүлжээний байгууллагуудаас авсан тодруулга, техникийн нөхцөлүүдийг хангах, холбогдох бусад байгууллагуудтай зөвшилцэх ажлыг Захиалагчтай хамтран хийх;</li> <li>Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн хурдны авто зам болон хий дамжуулах хоолойн олон улсын төслийн чиг шугамтай уялдуулах;</li> <li>Хөдөлгөөн ихтэй, томоохон широон замтай хэсэгт том оврын авто машин багтахуйц хэмжээний ижил бус төвшний гүүрэн гарц, хоолой төлөвлөхөд анхаарах;</li> </ul> <p>Байгаль, хүн, ан амьтан, хүрээлэн буй орчныг хамгаалах нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>Төмөр замын трассын зураг төслийг гүйцэтгэхдээ байгаль орчинд ээлтэй зэрлэг ан амьтан болон бэлчээрийн малын хөдөлгөөнд саад учруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх Улархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц Ерөнхий шаардлага MNS 6735:2018, Тал хээр, .gov цэлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц Ерөнхий шаардлага MNS 6515:2015 стандартуудыг баримтлан гарцуудыг төлөвлөх;</li> <li>Зэрлэг амьтдын нүүдлийн замыг чөлөөтэй байлгах, гарц, гармыг төлөвлөхдөө, мэргэжлийн байгууллагын судалгааны үндсэн дээр төлөвлөх – Биологийн хүрээлэнтэй нягт хамтран ажиллах;</li> <li>Түүх соёлын дурсгалт газрууд, ой мод, гол горхи, мөнх цэвдэгтэй бүсийг хөндөхгүйгээр төлөвлөх – Газарзүйн хүрээлэнтэй хамтран ажиллах;</li> <li>Археологи, плантелогийн судалгааны талбайг хөндөхгүйгээр төлөвлөх - Археологи, плантелогийн хүрээлэнтэй хамтран ажиллах;</li> <li>Төмөр замын дагууд дайран өнгөрч буй байгалийн үзэсгэлэнт газруудыг үзэх боломжийг бүрдүүлэх, харагдах байдал, гадаад үзэмж, гоо зүйн асуудалд анхаарах;</li> <li>Мал, амьтны гарц гармыг төмөр замтай 1 төвшинд бус, аль болох 2 өөр түвшинд төлөвлөх, Мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн судалгаа, дүгнэлтийг үндэслэн сэтэрхийтэй хэсэгт төслөх бол олон улсын жишигт нийцсэн дээгүүр гарцыг төлөвлөж өгөх;</li> <li>Богдхан төмөр замын трасс нь хүн ам ихтэй нийслэл хотын захын дүүргүүдийн суурьшлын бүсийг дайран гарч буй тул Улаанбаатар хотын бүсийг хөгжүүлэх шат шатны</li> </ul>
--	--

		<p>хөтөлбөр, төлөвлөгөө, барилга байгууламж, хот төлөвлөлт, нийгмийн дэд бүтэцтэй холбоотой бодлогын чанартай, батлагдсан төсөл хөтөлбөр түүний зураг төсөлтэй уялдуулах;</p> <ul style="list-style-type: none"> <li>Бусдын өмчлөл, эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгө, инженерийн дэд бүтцийн байгууламж, эрх үүссэн нэгж талбарыг дайрахгүй, тэдгээрийг хөндөхгүй байх боломжийг судлан шаардлагатай хэсэгт чигийг өөрчлөх, зурvas газрын хил хязгаар нь зохих журмын шаардлагыг хангаж байхаар төслөх;</li> <li>Зам, тээврийн салбараас гарч буй аюултай болон ахуйн хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд хог хаягдлын менежмент, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр төлөвлөх;</li> <li>Хүн ихээр суурьшсан суурин газар болон хүн, машины хөдөлгөөн ихтэй газар нүхэн гарцыг сайтар төлөвлөх;</li> </ul>
14.	Тусгай нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>Эстакад, туннелийн байршил геологи, геотехникийн судалгаанаас шалтгаалан өөрчлөгдөх нөхцөлд ажлын зургийг уялдуулан төлөвлөх;</li> <li>Трассын чиг өөрчлөгдсөн хэсэгт геодезийн M1:1000 болон M1:500 масштабтай байр зүйн зураглалын ажлыг хийх, тайлан боловсруулах</li> <li>Төмөр замын чигийн дагууд газар орны хэлбэр дүрсийн онцлогоос шалтгаалж 18 м-ээс өндөр далан, 16 м-ээс гүн ухмал гарах нөхцөл үүсвээс зохих үндэслэл буюу нарийвчилсан судалгаа, тусгайлсан тооцоо, шийдлүүд шаардлагатай болох тул аль болох инженерийн хүнд нөхцөлөөс зайлсхийхийг эрмэлзэх;</li> <li>Төмөр замын чигийн дагууд зэрлэг болон тэжээвэр малын бэлчээр, ан амьтны шилжилт хөдөлгөөний жим, нүүдэл, усны байршлыг судлан төмөр замыг хөндлөн гарах гарцуудыг уялдуулж шийдвэрлэх, шилжилт хөдөлгөөнийг хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлсэн байх;</li> <li>Өртөө, зөрлөгийн замын даланг төслөхдөө техникийн шаардлагыг хангасан инженерийн шугам сүлжээний байгууламжуудыг зам хөндлөн гаргах болон дагуу тавихад зориулсан нэгдсэн хоолой, сувагчлалыг Захиалагчаас өгсөн мэдээлэл, баримт бичгийг үндэслэн тодорхой байршуудад төслөн уялдуулж шийдэх;</li> <li>Төмөр замын трассын нэн ялангуяа сэтэрхийтэй хэсэгт, нам далантай, сэтэрхийгээс далантай хэсэгт шилжих нэг түвшиний газруудад сэтэрхийн хамгаалах даланг сэтэрхийн эхлэл төгсгөлөөс хоёр тийш 60 метрээс багагүй уртасгаж зураглах, эгнээлэх, өндөрлөх зэрэг цасанд дарагдахаас хамгаалах арга хэмжээний төлөвлөлт хийх</li> <li>Ухмал буюу сэтэрхий төлөвлөгдсөн газарт хатуу болон зөөлөн ухмалын зургийн хил заагийг анхнаас нь ялгаж, хөндлөн огтлолын зураг болон тоо хэмжээг үнэн зөв тооцоолох;</li> <li>Төмөр замыг цасанд дарагдах газруудад хамгаалах таримал мод бут гэх мэт зурvas газар байгуулах тооцоо, судалгааг хийж зураг төсөлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсвэл захиалагч болон зураг төсөл зохиогч</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн /ASTM D422/;</li> <li>Хөрсний байгалийн чийгийг тодорхойлох /ASTM D318/;</li> <li>Хөрсний (шаварлаг) ул хөрсний уян налархайн үзүүлэлт /ASTM D 4318/;</li> <li>Ул хөрсний хэв гажилтын модуль тодорхойлох компрессын 2 муруйн туршилт /MNS D3478: 1983/, /MNS 2314/;</li> <li>Ул хөрсний зууралдлын хүч, дотоод үрэлтийн өнцөг тодорхойлох сдвигийн туршилт / MNS Б3478:1983/, /MNS 2315/;</li> <li>Хөрсний Калифорнийн даацын илтгэлцүүл тодорхойлох туршилт CBR /ASTM D1883/;</li> <li>Ул хөрсний оновчтой чийгийн агууламж /OMC/, хөрсний хамгийн их хуурай нягтрал /MDD/-ыг тодорхойлох прокторын туршилт /ASTM D1557/;</li> <li>Онцгой шинж чанартай хөрсний үзүүлэлтүүдийг тодорхойлох;</li> </ul>
16.	Лабораторийн туршилт шинжилгээ	<ul style="list-style-type: none"> <li>Зураг төсөл гүйцэтгэх ажлын явцыг 7 хоног тутам тайлагнаж, зөвшилцөнө.</li> <li>7 хоног бүрийн хурал нь 2 талын зөвшилцөх асуудлын жагсаалтын дагуу хуралдах бөгөөд хурлаас гарсан шийдвэрийг хурлын тэмдэглэл хөтлөн баталгаажуулна.</li> <li>Зураг төсөл, түүний иж бүрэн баримт бичиг нь Захиалагч бүрэн зөвшөөрч баталснаар баталгаажна.</li> </ul>
17.	Хяналт	<ul style="list-style-type: none"> <li>Иж бүрэн зураг төслийн баримт бичиг нь "Богдхан төмөр замын төсөл"-ийн хэмжээнд мөрдөгдэж буй баримт бичгийн журмын дагуу бэлтгэгдсэн байх;</li> <li>Захиалагчид хүргүүлж буй бүх зураг төсөл, баримт бичиг нь давтагдахгүй өөрийн гэсэн дугаартай байх ёстой;</li> <li>Бүх баримт бичигт техникийн шаардлага, тайлбар бичиг, тайлан, тооцоолол, тоо хэмжээ гэх мэт орох ба бүгд тусдаа дугаартай, бүгд баримт бичиг хяналтын хуудастай байх;</li> <li>Нарийвчилсан зураг нь хяналтын хуудаснаас гадна, зургийн жагсаалттай байх;</li> <li>Нарийвчилсан зургийн хуудас бүр давтагдахгүй өөрийн гэсэн дугаартай, мөн зургийн хуудас бүр дээр зургийн өөрчлөлт (revision)-ийг тэмдэглэсэн байх;</li> <li>Зураг төсөл түүнтэй холбоотой баримт бичгийг хэнд, хэрхэн хүргүүлэх харилцааны матрицыг албан ёсоор захиалагчид мэдэгдэж батлуулна;</li> <li>Тайланг захиалагчийн баталсан тайлангийн иж бүрдэл, загварын дагуу ирүүлэх;</li> <li>Зураг төслийг хүргүүлэхдээ зураг төсөл болон түүнд ашигласан бүхий л тооцоо, судалгааг хэвлэмэл болон AutoCad DWG, MS Excel, MS Word, GeoTiff, IMG, PDF зэрэг эх файлуудыг CD/DVD-д хавсарган албан тоотоор ирүүлнэ;</li> <li>Галт тэрэгний тээх нэвтрүүлэх чадварын тооцоо;</li> <li>Зүтгүүрийн татахын тооцоо;</li> </ul>
18.	Тайлан	<ul style="list-style-type: none"> <li>Суурь бүтцийн газрын дарга</li> </ul>

Хянасан:

*Батзориг*

Т.Батзориг

Суурь бүтцийн газрын дарга

*Ш.Алтанхуяг*

Ш.Алтанхуяг

Боловсруулсан:

Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга

*Э.Чанцалдулам*

Зураг төсөл, технологийн хэлтсийн дарга